ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

ҮНИЙН САНАЛ АВАХ БАРИМТ БИЧИГ

Төслийн нэр: Шуудангийн хайрцаг хийх /Урт булаг баг/

Төслийн дугаар: ОР-134/2018

Орхон аймаг
2018 он

ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо:**2018 оны 12 дугаар сарын 17-ны өдөр**
Тендер шалгаруулалтын нэр: **Шуудангийн хайрцаг хийх /Урт булаг баг/**
Тендер шалгаруулалтын дугаар: **ОР-134/2018**

Орхон аймгийн ЗДТГ нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Шуудангийн хайрцаг хийх /Урт булаг баг/** нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулинд нийцүүлэн тендерийн баримт бичигт тодорхойлсон журам болон Харьцуулалтын аргаар гүйцэтгэгчийг сонгоно.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул (www.tender.gov.mn) хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүй татаж авна уу.

Тендерийн баримт бичгийг илгээхийн өмнө 30000 /гучин мянган/ төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байна.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45** хоногийн дотор хүчинтэй байна.

Үнийн саналыг **2018 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 09 цаг 00 минут**-аас өмнө цахимаар ирүүлэх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 12 дугаар сарын 25-ны 09 цаг 30 минутад** Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны **Сургалт мэдээллийн танхимд** цахимаар нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газрын 70358570 утсаар авч болно.

Орхон аймгийн Орон нутгийн өмчийн газар
Нутгийн удирдлагын ордон 1 давхар 113 тоот өрөө
Утас:70358570

Хоёр. **ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА**

1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.

2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

3. Тендерийн иж бүрдэл

Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Үнийн санал; /маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ./
- Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх
- Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх
- Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх
- Татварын цахим тодорхойлолт - Татварын ерөнхий газрын **www.e-tax.mta.mn** сайтыг ашиглан цахим тодорхойлолт (Хэвлэмэл хуудсыг тендерт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ.)
- Шүүхийн тодорхойлолт
- Санхүүгийн тайлан-2017 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж аудитын дүгнэлтийн хамт эхээс скайнердаж ирүүлнэ.
- Чадварын мэдээлэл: Бараа бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, хүлээлгэн өгсөн акт / болон бусад баримт бичиг ирүүлэх/
- Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх
- Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор танилцуулгын хамт ирүүлэх
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдэл ирүүлэх
- Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх
- Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/

Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөх эсвэл түүний агуулгыг өөрчилж ирүүлэх, баталгаажилтгүй, мөн хуурамч нотлох баримтууд ирүүлсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.

4. Тогтмол үнэ

4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.

5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд

5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.

5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа	6.1.	Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш ***45*** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх	7.1.	Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
	7.2.	Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ***ТШӨХ-д*** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
	7.3.	Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл	8.1.	Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав.**ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ**

ТОӨЗ-ны холбогдох заалт	**Шалгуур үзүүлэлт**
ТОӨЗ 1.1	➢ Үнийн санал; /маягтын дагуу, баталгаажуулан ирүүлнэ./ ➢ Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас скайнердаж ирүүлэх ➢ Компанийн дэлгэрэнгүй танилцуулга ирүүлэх ➢ Захирлын цахим иргэний үнэмлэхний эх хувиас скайнердаж ирүүлэх ➢ Татварын цахим тодорхойлолт - Татварын ерөнхий газрын **www.e-tax.mta.mn** сайтыг ашиглан цахим тодорхойлолт (Хэвлэмэл хуудсыг тендерт ирүүлэх ба ингэхдээ хуудсын доод хэсэгт байрлах тоо, тэмдэгт орсон 36 оронтой нууц дугаарыг гаргацтай байхаар ирүүлнэ.) ➢ Шүүхийн тодорхойлолт ➢ Санхүүгийн тайлан-2017 оны санхүүгийн тайланг аудитаар баталгаажуулж аудитын дүгнэлтийн хамт эхээс скайнердаж ирүүлнэ. ➢ Чадварын мэдээлэл: Бараа бүтээгдэхүүн нийлүүлж байсан туршлагын мэдээлэл /гэрээ, хүлээлгэн өгсөн акт / болон бусад баримт бичиг ирүүлэх/ ➢ Нийлүүлэхээр санал болгож буй барааны техник үзүүлэлт /техникийн дэлгэрэнгүй тодорхойлолт/-ыг захиалагчийн шаардсан техникийн тодорхойлолттой харьцуулж хүснэгтээр баталгаажуулан ирүүлэх ➢ Нийлүүлэх барааны зургийг өнгөтөөр, харагдах байдал бүрэн тодоор танилцуулгын хамт ирүүлэх ➢ Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14.1-т заасан нөхцөл үүсээгүй тухай мэдэгдэл ирүүлэх ➢ Тендерийн баримт бичгийн гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрч байгаа талаар мэдэгдэл ирүүлэх ➢ Баталгаат хугацаа олгох албан бичиг ирүүлэх /1 жилээс багагүй байх/ Тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлэхгүй байх, маягтыг дутуу бөглөх эсвэл түүний агуулгыг өөрчилж ирүүлэх, баталгаажилтгүй, мөн хуурамч нотлох баримтууд ирүүлсэн тохиолдолд тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
ТОӨЗ 2.1	Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь: Уг тендер нь цахим тендер шалгаруулалтын журмаар зохион байгуулагдаж байгаа тул тендерт оролцогч нь Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn) –нд өөрийн аж ахуйн нэгжийн тоон гарын үсгээр нэвтрэн орж тендерийн материалаа цахим хэлбэрээр илгээнэ. Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь: Огноо: **2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр** Цаг: **09 цаг 00 минут** Цахим тендерийн урилгад заасан тендер хүлээн авах эцсийн хугацаа нь цахим системийн серверийн цагаар тооцогдох бөгөөд хугацаа хоцорсон тендерийг хүлээж авахгүй.
ТОӨЗ 2.1	Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд: ТЕНДЕРИЙГ ЦАХИМААР ДАРААХ ГАЗАРТ НЭЭНЭ. Байшин, гудамжны нэр: **Орхон аймгийн ЗДТГ, Нутгийн Удирдлагын ордон** Давхар болон өрөөний дугаар: **Нэг цэгийн үйлчилгээ, Орон нутгийн өмчийн газрын Худалдан авах ажиллагааны Сургалт мэдээллийн танхим** Аймаг, хот: **Орхон аймаг, Баян-Өндөр сум** Улс: **Монгол Улс** Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: **2018 оны 12 дугаар сарын 25-ны өдөр** Цаг: **09 цаг 30 минут**
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: **Багцгүй.**

БАТЛАВ:

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ

Гурав. **ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ**

1. **Барааны тодорхойлолт:** Нийлүүлэгдэх бараа нь дор дурьдсан техникийн тодорхойлолт, үзүүлэлт, тоо ширхэг хангасан байна.
2. **Стандарт:** Нийлүүлэгдэх бараа нь Монгол улсын MNS 5978:2009 стандартад нийцсэн байна.
3. **Баглаа, боодол:** Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолыг стандартын дагуу хийж эцсийн цэгт хүргэнэ. Түүнээс гарах бүх эрсдлийг нийлүүлэгч хариуцна.
4. **Шалгалт, туршилт:** Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.
5. **Угсрал, суурилуулалт:** Барааг нийлүүлэгч угсарч, суурилуулж өгнө.

№	Барааны нэр	Хэмжих нэгж	тоо ширхэг	Тавигдах шаардлага
1	Шуудангийн хайрцаг	ш	1500	-Монгол улсын Шуудангийн хайрцаг MNS 5978:2009 стандартын 3.3 дахь заалт Хаягын хүргэлтийн буюу орцны хайрцаг /Шуудангаар ирсэн илгээмжийг хаягт, эзэнд нь хүргэж гардуулах шатан дахь аюулгүй байдал, нууц хамгаалалтын шаардлагыг хангасан, шуудан холбооны байгууллагаас хэрэглэгчдэд зориулан эзэмшүүлсэн, нийтийн хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон үйлдвэрлэлийн барилга байгууламжид байршуулах шуудангийн хайрцаг/ тодорхойлолтыг хангасан байна. **-Шуудангийн хайрцаг нь** MNS 5978:2009 стандартын 3-р хүснэгтэд заасан битүүмжилсэн хайрцаг байна. Битүүмжилсэн шуудангийн хайрцагт тавигдах шаардлага, аюулгүй байдал: Монгол улсын шуудангийн хайрцагны стандарт MNS 5978:2009 стандартын 4, 4.3, 5.2 заалтыг хангасан байна. -Шуудангийн хайрцагийг /Хаягын хүргэлтийн хайрцаг/-ыг MNS 5978:2009 стандартын 8.3.1, 8.3.3 –д заасны дагуу байрлуулна. Монгол улсын Шуудангийн хайрцаг MNS 5978:2009 стандартыг хавсаргав. Шуудангийн хайрцаг нь: ➢ Тээвэрлэх, буулгах, байрлуулахад хөнгөн, бат бөх материалаар хийгдсэн байх ➢ Хэрэглэгч тус бүрт зориулсан нүдтэй, тус бүртээ хаалга, цоожтой байх

				➢ Шуудангийн аюулгүй байдлыг хангасан байх ➢ Тухайн байр орцны айлын тоотой тэнцүү хэмжээгээр байршуулах боломжтой байх ➢ Цэвэр , өнгө үзэмжтэй байх ➢ Хэрэглэгч тус бүрт оноосон дугаарлалттай байх

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Барааны тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжих нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг (Ажлын талбай)	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Бараа нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа *(Тендерт оролцогч энэ баганыг бөглөнө)*
1	2	3	4	5	6	7	8
1	Шуудангийн хайрцаг	1500	ш	Орхон аймгийн Баян-өндөр сумын Урт булаг багийн байрнуудад суурилуулж өгнө.	14 хоног	21 хоног	[Гэрээ хүчин төгөлдөр болсноос хойших хугацааг бичих]

Дөрөв. **ЖИШИГ МАЯГТ**

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

ОРХОН АЙМГИЙН ЗДТГ-ЫН ДАРГА Д.СОЁЛЧХҮҮ ТАНАА

1. Бид, *[тендерт оролцогчийн нэр]* дор дурдсан барааг ***[санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр]*** төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу ***[тоо]*** хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. **ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ**

1. Шалгах болон турших	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн барааND олгодог баталгаат засварын хугацаа ***[1]*** жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш ***[ГТН-д заасан тоо]*** хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээгүй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
11. Маргааныг шийдвэрлэх	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. **ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ**

1. Шалгах болон турших (ГЕН – 1)

a. Барааг хүлээн авах комисс шалгаж , туршиж актаар хүлээн авна.

b. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч, эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, туршилт хийх эрхтэй. Шалгалт, туршилтыг барааг хүргэх газар буюу нийлүүлэх эцсийн цэгт явуулна. Шалгалт, туршилтаар бараа нь техникийн тодорхойлолтыг хангаагүй тохиолдолд захиалагч тус бараанаас татгалзах эрхтэй ба нийлүүлэгч тус барааг үнэ төлбөргүй солих эсвэл техникийн тодорхойлолттой нийцүүлэх бүхий л арга хэмжээ авна.

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)

a. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) барааны гарал үүслийн гэрчилгээ.

Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.

3. Баталгаат засвар (ГЕН-5)

a. Баталгаат засварын тусгай шаардлага. 1 ЖИЛЭЭС БАГАГҮЙ БАЙХ

4. Төлбөр (ГЕН – 7)

a. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнэ төгрөгөөр төлөгдөнө.

1. **<u>Урьдчилгаа төлбөр:</u> Олгохгүй.**
2. **<u>Бараа ачигдсаны дараа төлөх төлбөр:</u> Олгохгүй.**
3. **<u>Барааг хүлээн авч акт үйлдсэний дараа төлөх:</u>** Захиалагчийн хүлээн авсан тухай актыг үндэслэн төлбөрийг 100 хувь олгоно.

5. Алданги оногдуулах (ГЕН - 9)[1]

a. Алданги оногдуулах хувь: **Гэрээний үнийн дүнгийн 0,1 хувиар хугацаа хэтэрсэн хоног тутамд тооцож гэрээний үнийг бууруулна.**

b. Алдангийн нийт дүн: **Алдангийн дээд хязгаар нь гэрээний нийт дүнгийн 10 хувь байна. Дээд хязгаар хэтэрсэн тохиолдолд захиалагч тал гэрээг цуцална.**

---

[1] Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. **ГЭРЭЭНИЙ МАЯГТ**[2]

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ	**НИЙЛҮҮЛЭГЧ**
_____	_____
(Тамга, тэмдэг)	(Тамга, тэмдэг)
_____	_____
(Гарын үсэг)	(Гарын үсэг)
_____	_____
(Албан тушаал)	(Албан тушаал)

***[Тендер шалгаруулалт/гэрээний нэр]* гэрээ.**

Дугаар № *[Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]*

..... хот/аймаг

Нэг талаас ***[захиалагчийн нэр]*** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас ***[нийлүүлэгчийн нэр]*** (цаашид "нийлүүлэгч" гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ___ сарын ____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь ***[гэрээний нэр, дугаар]***-г (цаашид "бараа" гэх) ***[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]*** (цаашид "гэрээний үнэ" гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ___-наас _____ оны __ дугаар сарын ___-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

   Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
   Бусад шаардлагатай баримт бичиг[3];
   Үнийн санал;
   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;
   Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
   Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дараалын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

---

[2] Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

[3] Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:	**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**
[Албан тушаал, нэр] *[Гарын үсэг]*_____	*[Албан тушаал, нэр]* *[Гарын үсэг]*_____
ТАМГА	ТАМГА
[Захиалагчийн хаяг] *[Утас/факсын дугаар]* *[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*	*[Захиалагчийн хаяг]* *[Утас/факсын дугаар]* *[Харилцагч банкны нэр, дансны дугаар]*

МОНГОЛ УЛСЫН ШУУДАНГИЙН ХАЙРЦАГНЫ СТАНДАРТ

Ашиглалтын код 03.240

Шуудангийн хайрцаг	**MNS 5978 : 2009**
Postal box	**MNS 5111 : 2006,** **MNS 5112 : 2002-ын оронд**

Энэ стандарт нь 2009 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн хүчинтэй.

1. Хамрах хүрээ

Энэ стандартаар шуудангийн технологи ажиллагаанд хэрэглэх шуудангийн хайрцагны төрөл, техникийн шаардлага, тэдгээрийг үйлдвэрлэх, шалгаж хүлээн авах, байрлуулахад тавих шаардлагыг тогтооно.

2. Нэр томьёо, тодорхойлолт

Энэ стандарт дараах нэр томьёо, тодорхойлолтыг хэрэглэнэ.

2.1 Шуудангийн хайрцаг

Шуудангийн үйлчилгээнд хэрэглэх шуудангийн илгээмжийг илгээгчээс хүлээн авах болон хаягт эзэнд нь хүргэх ажиллагаанд хэрэглэх зориулалттай шуудангаар үйлчлэгчээс тодорхой цэгт байрлуулсан хайрцаг.

3. Шуудангийн хайрцагны төрөл

3.1 Захидал Цуглуулах хайрцаг

Энгийн битүүмжилсэн ба ил захидал зэргийг үйлчлүүлэгчээс бололцоотой үедээ явуулах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор шуудангаар үйлчлэгчээс хүн амын нягтрал, хөдөлгөөн ихтэй газар, албан байгууллага, гудамж талбайд суурилуулсан хайрцаг

3.2 Салбарын хайрцаг

Шуудангийн илгээмжүүдийг хаягт эзэнд нь олгохын тулд шуудангаар үйлчлэгчдээс өөрийн салбарт байрлуулан үйлчлүүлэгчдэд хөлсөөр эзэмшүүлж байгаа задгай буюу битүүмжилсэн хайрцаг.

3.3 Хаягийн хүргэлтийн буюу орцны хайрцаг

Шуудангаар ирсэн илгээмжийг хаягт эзэнд нь хүргэж гардуулах шатан дах аюулгүй байдал, нууц хамгаалалтын шаардлагыг хангасан, шуудан холбооны байгууллагаас хэрэглэгчдэд зориулан эзэмшүүлсэн, нийтийн, хувийн эзэмшлийн орон сууц, олон нийтийн болон үйлдвэрийн барилга байгууламжид байрлуулах шуудангийн хайрцаг.

4. Шуудангийн хайрцагт тавих ерөнхий шаардлага

Шуудангийн хайрцаг нь шуудангийн үйлдвэрлэл, үйлчилгээний төгсгөлийн дамжлага болох шуудангаар дамжих илгээмжийг хаягт эзэнд гардуулах нөхцөл, битүүмжлэл, нууц хадгалалтын шаардлага болон "Шуудангийн аюулгүй байдал MNS 5536:2005" стандартын шаардлагад нийцсэн байна.

4.1 Захидал цуглуулах хайрцагт тавих шаардлага

4.1.1 Захидал цуглуулах хайрцаг нь улаан өнгөтэй байх ба хэлбэр дүрс, овор хэмжээний хувьд тогтоосон хязгаарын дотор ямар ч байж болно.

4.1.2 Захидал цуглуулах хайрцгийн 3 талын хэмжээсийн байж болох хамгийн бага хэмжээ 1-р хүснэгтэнд үзүүлэв.

1-р хүснэгт – захидал цуглуулах хайрцагны хэмжээсүүд

Хайрцагны төрөл	Урт (А) мм	Өргөн (В) мм	Өндөр (Н) мм
Гудамж талбайд суурилуулах	400	400	600
Хананд бэхэлж суурилуулах	240	240	320
Шуудангийн салбарт байрлуулах	400	400	600

4.1.3 Захидал цуглуулах хайрцгийн нүүрэн талд тухайн шуудангаар үйлчлэгчийн таних тэмдэг лого, шуудангийн байгууллагын нэр, уг хайрцгийг нээх цагийн хуваарь болон "Шуудан" гэсэн үгийг цагаан өнгөөр бичсэн байна. Шуудангаар үйлчлэгчийн лого болон нэр нь "Шуудан" гэсэн үгийг агуулсан болдавхардууланбичихгүйбайжболно.

4.1.4 Захидал цуглуулах хайрцаг нь бат бэх цоожтой, шуудангийн аяулгүй байдал, нууц хадгалалтыг бүрэн хангасан, доторх захидлуудаа цас, бороо, нар зэрэг байгалийн болон бусад гадны механик нөлөөллөөс хамгаалахаар хийгдсэн байна.

4.1.5 Захидал цуглуулах хайрцаг нь нүүрэн талдаа захидал хийх зориулалт бүхий гадны нөлөөллөөс хамгаалах хавхаг буюу хамгаалалт бүхий нарийн цонхтой байх ба уг цонхны урт нь 230 мм ("Шуудангийн дугтуй. Тэмдэглэгээ ба хэмжээ. Техникийн шаардлага MNS 3963:1995" стандартаар тодорхойлсон С5 дугтуй багтахуйц), өргөн нь 5 мм-ээс илүүгүй хэмжээтэй байна.

4.1.6 Захидал цуглуулах хайрцаган дотор захидал цуглуулах зориулалтын богц байрлуулах ба богцыг өлгөх буюу тусгай ховил бүхий тэлэгч ашиглан тогтооно.

4.1.7 Захидал цуглуулах хайрцаг богцтой шууданг гэмтээлгүй, чөлөөтэй авч болох цоож бүхий тусгай хаалгатай байна.

4.2. Салбарын хайрцагт тавих шаардлага

4.2.1 Салбарын битүүмжилсэн буюу задгай хайрцаг нь шуудангийн аюулгүй байдал, нууц хадгалалтын шаардлагыг бүрэн хангасан байна.

4.2.2Салбарын хайрцаг тус бүрийг дараалсан дугаараар давхардуулалгүй дугаарлах ба хайрцгийг гаргацтай, суурь өнгөнөөс ялгарах өнгөөр жигд дугаарлана. Дугаарын цифрийг хайрцгийн хэмжээнээс хамааруулан 2-р хүснэгтэд зааснаар сонгоно.

2-р хүснэгт – салбарын хайрцагны дугаарын цифрийн хэмжээ

Хэмжээ	Дугаарын цифрийн хэмжээ		
	Өндөр, ММ	Өргөн, ММ	Бичлэгийн өргөн, ММ
Дээд	65	35	7

Доод	20	15	3

4.2.3Салбарын битүүмжилсэн хайрцгийг хоорондоо түлхүүр үл таарах далд цоожоор тоноглосон байна.

4.2.4 Хэрэглэгчийн эрэлт хэрэгцээ, байр талбайн багтаамжтай уялдуулан нэг салбарт байршуулах хайрцагны тоо, хэмжээг шуудангаар үйлчлэгч тодорхойлно.

4.2. 5 Салбарын хайрцгийг үеэлсэн байдлаар байрлуулна.

4.2.6 Салбарын хайрцагны хэмжээг 3-р хүснэгтэнд заасан.

3-р хүснэгт – Хайрцагны хэмжээс

Төрөл	Урт (а), мм	Өргөн (В), мм	Өндөр (Н), мм
Задгай хайрцаг	180	200	180
	240	310	100
	240	380	160
	270	360	220
Битүүмжилсэн хайрцаг	160	200	160
	180	200	180
	220	325	70
	220	325	140

4.2.7Салбарын хайрцагны гурван талын хэмжээс нь 4.2.6-д зааснаас багагүй байх ба хэлбэрийн хувьд заавал тэгш өнцөгт байх шаардлагагүй.

4.3 Хаягийн хүргэлтийн хайрцагт тавих шаардлага

Хаягийн хүргэлтийн хайрцагт тавих шаардлагыг энэ стандартын 4.2.2, 4.2.3, 4.2.5, 4.2.6, 4.2.7-р заалтуудаар тогтооно.

5. Шуудангийн хайрцгийг үйлдвэрлэх

5.1 Захидал цуглуулах хайрцаг

Захиалагчийн саналыг үндэслэн, шуудангийн илгээмжийн аюулгүй байдал, байгал цаг агаарын болон гадны механик нөлөөллөөс хамгаалж чадахуйц галд тэсвэртэй, бат бөх материалаар үйлдвэрлэнэ. Захидал цуглуулах хайрцаг нь улс үндэстний түүх, соёлын өв уламжлал, онцлогийг тусгасан гоёмсог загвартай байж болно. /В хавсралтыг үзнэ үү/.

5.2 Хаягийн хүргэлтийн болон салбарын хайрцаг

Захиалагчийн саналд нийцсэн овор хэмжээтэй, бат бөх, цас, бороо, ус, чийг салхи зэрэг гадны нөлөөнөөс шуудангийн илгээмжийг бүрэн хамгаалах материалаар, зохих журмын дагуу үйлдвэрлэнэ.

6. Шуудангийн хайрцгийг шалгаж, хүлээн авах

6.1 Шуудангийн хайрцгийг энэ стандартын шаардлагатай нийцүүлэн шалгаж хүлээн авна.
6.2 Шуудангийн салбарын 10 хайрцаг бүрээс 1-ийг түүвэрлэн авч, тэдгээрийн цоож хоорондоо таарч буй эсэхийг шалгана.

7. Шуудангийн хайрцгийг тээвэрлэх

Шуудангийн хайрцагны өнгө будгийг халцлахгүй, хэлбэр дүрсийг эвдэхгүйгээр байрлуулж бэхэлгээ хийж тээвэрлэнэ.

8. Шуудангийн хайрцгийг байрлуулах

8.1 Захидал цуглуулах хайрцаг

Захидал цуглуулах хайрцгийг барилга байшингийн хананд буюу гудамж талбайд байрлуулахдаа 100 мм-ээс дээш урттай 4-өөс доошгүй шургаар сайн хөдөлгөөнгүй бэхэлж тогтооно. Хүндрүүлэгчтэй хайрцгийг нэмэгдэл бэхэлгээгүйгээр шуудангийн үйлчилгээний танхимд байрлуулна.

8.2 Салбарын хайрцаг

Салбарын битүүмжилсэн хайрцгийг тухайн шуудангийн салбарын үйлчилгээний танхимд, задгай хайрцгийг байнгын харуул хамгаалалт буюу ялгагчийн байнгын танхимд, тухайн салбарын ялгалтын өрөөнд буюу нууцлалтыг хадгалах боломжтой тусгайлсан талбайд байрлуулна.

8.3 Хаягийн хүргэлтийн хайрцаг

8.3.1 Шуудангийн хаягийн хүргэлтийн хайрцгийг шинээр баригдах орон сууц барилга байгууламжийн дотор байрлах тохиолдолд шалны түвшнээс дээш 0,5 м-ээс багагүй өндөрт, хананд бэлтгэсэн нүх /ниш/-д байрлуулна. Шуудангийн хаягийн хүргэлтийн хайрцгийг байрлуулахаар төлөвлөөгүй /одоо ашиглагдаж байгаа/ орон сууц, барилга байгууламжийн дотор хананд байрлуулах тохиолдолд шалны түвшнөөс дээш 1 м-ээс дээш өндөрт, гадна хананд буюу тусад нь байрлуулна. Шуудангийн хайрцгийн байрлалыг А хавсралтад үзүүлэв.

8.3.2 Барилга байгууламжийн зураг төсөвт шуудангийн хаягийн хүргэлтийн хайрцгийг шуудангаар үйлчлэгчийн үйлчилгээ болон аюулгүй байдал, харуул хамгаалалт, хяналтын нэгдсэн байдлыг хангасан байхаар заавал төлөвлөн тусгаж байрлуулна.

8.3.3 Шуудангаар үйлчлэгч нь хаягийн хүргэлтийн хайрцгийг шуудангаар үйлчлүүлэгчдэд зориулан үйлчилгээ үзүүлэх шаардлага, аюулгүй байдал хангасан цэг /төвлөрсөн нэг цэгийн үйлчилгээтэй үйлчилгээний төв, банк, албан байгууллага гэх мэт эсвэл тусгайлан зориулж байгуулсан цэг/-т байрлуулна.